



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2024 оны 10 сарын 03 өдөр

Дугаар Б/65

Өмнөдэлгэр сум

Э.Нямгэрэлд сахилгын шийтгэл
ногдуулах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.3 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Жижүүр хамгаалагч Эрдэнэбулагийн Нямгэрэл нь ажлаас хоцрох, өгсөн үүрэг даалгаврыг удаа дараа биелүүлээгүй, байгууллагын үйлчилгээний стандартыг удаа дараа зөрчсөн зөрчил гаргасан тул 2024 оны 10, 11 дүгээр сарын үндсэн цалинг 15 хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Гаргасан зөрчил дутагдалдаа дүгнэлт хийж цаашид алдаа дутагдал гаргахгүй, ёс зүйн хэм хэмжээг сахин ажилдаа хариуцлагатай хандаж ажиллахыг жижүүр хамгаалагч Э.Нямгэрэлд үүрэг болгосугай.

3. Байгууллагын үйлчилгээний стандартын хэрэгжилтэд хяналт тавих, албан хаагчдын сахилга бат, хариуцлага, дэг журмын гүйцэтгэлийн хэрэгжилтийг хангах сургалт мэдээлэл хийж ажиллахыг Дотоод хяналтын багийн ахлагч Б.Энхбаяр, Ёс зүйн зөвлөлийн дарга Х.Цэсэндүлам-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нягтлан бодогч (Л.Сарантуяа)-д даалгасугай.

ЭРХЛЭГЧ



О. ГАНЦЭЦЭГ